



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, тус газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал Дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Өгөөмөр Алтай ХХК-ийн “Өгөөмөр Алтай” зочид буудлын 18/348, Касио ХХК-ийн “Ану” дэн буудлын 18/145, Тайванбаатар ХХК-ийн “Бодонч” амралтын газрын 18/339 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.


1150500333

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.


7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



5284025 СБТ 48936 1118200502

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 09
сарын 18 өдрийн А/76 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



**ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

2019 оны 09 дүгээр сарын 18-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Зул Оюу ХХК	5089565	Би жи	БЗД-ийн, 5-р хороо, 15-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө 84 тоот
2	Өгөөмөр Алтай ХХК	2676192	Өгөөмөр Алтай	СХД-ийн, 12-р хороо, Өнөр хорооллын гудамж 37-1 тоот

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 09
сарын 18 өдрийн А/76 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284125 СБТ-48936 1118263502

**ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

2019 оны 09 дүгээр сарын 18-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Касио ХХК	2664402	Ану	СХД-ийн, 27-р хороо, Толгойтын гудамж 22 тоот

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 09
сарын 13 өдрийн А/76 дугаар
тушаалын гуравдугаар хэвсрэлт

5284025 СБТ 48926 1118263002

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019 оны 09 дүгээр сарын 18-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Тайванбаатар ХХК	5337011	Бодонч	СХД-ийн, 21-р хороо, Дэлгэр булгийн ам, 1-р гудамж 1-5 тоот

-ооОоо-